



АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨНӨӨС ӨГӨГДСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТ



2023 оны 05 дугаар сарын 15-ны өдөр

ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР



1. Бүх нийтээр мод тарих ажлын бэлтгэлийг хангаж зохион байгуулах. Модны суулгац үзэсгэлэн худалдаанд ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийг оролцуулах. Иргэдэд мэдээлэл өгч ажиллах.

Хугацаа: Тухай бүрд





Биелэлт: ХБТХОХ

Аймгийн Засаг даргын 2023 оны А/334 дүгээр захирамжаар “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, Ногоон Эрдэнэт хөтөлбөрийн хүрээнд бүх нийтээр мод тарих хаврын ажлын төлөвлөгөөг батлуулан дараах ажлуудыг зохион байгуулан ажиллаж байна.

- Мод тарих хүсэлтэй иргэдийн хэрэгцээг хангах зорилгоор 05 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн 5 хоногийн хугацаанд мод бут, сөөгийн тарьц, суулгацын үзэсгэлэн худалдааг А.Амарын талбай болон Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэнгийн арын авто зогсоолд зохион байгуулж байна. Үзэсгэлэн худалдаанд 12 иргэн аж ахуйн нэгж, нөхөрлөлүүд оролцож байна.





Биелэлт: ХБТХОХ

- Олон нийтийн оролцоотой мод тарих бэлтгэлийг хангаж хар шорооны нөөцийг бүрдүүлэн мод тарих байршлууд болох Сархиа уулын 2 цэг, Тарлан толгойн бэл, А1001 авто зам дагуух ойн зурвас зэрэг газруудад хар шорооны нөөцийг бүрдүүллээ.
- 2023 оны 5 дугаар сарын 12-ны өдөр 49 төрийн байгууллагуудын оролцоотой Сархиа уулын хийморийн овооны баруун талд бүх нийтийн мод тарих ажлыг зохион байгуулж, 1159 ширхэг шинэс модыг тарьж, цахимд бүртгүүллээ.





Биелэлт: ХБТХОХ

- Аймгийн Засаг даргын 2021 оны А/228 дугаар захирамжаар зарлагдсан “Ногоон Эрдэнэт” болзолт уралдаанд шалгарсан 5 иргэнийг Байгаль орчны салбарын байгууллагуудын нээлттэй хаалганы өдөрлөгөөр шагнаж урамшуулах ажлыг зохион байгууллаа. Бүх нийтийн мод тарих мэдээллийг Номин болон ETV телевизүүдээр болон Орхон аймгийн Байгаль орчин, Аялал жуулчлалын газрын цахим хаягаар иргэдэд хүргэж байна.
- Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын байгууллагуудын нээлттэй хаалганы өдөрлөгийг “ТАНЫ ОРОЛЦОО-БИДНИЙ ИРЭЭДҮЙД” уриан дор 2023 оны 05 дугаар сарын 11-ний өдөр А.Амарын талбайд зохион байгууллаа. Тус өдөрлөгт төрийн 7 байгууллага, байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэн ажилладаг томоохон 5 үйлдвэр, эко клубийн хүүхдүүд оролцож иргэдэд мэдээллийг түгээлээ.

Хэрэгжилт: Хэрэгжиж байна.



Урьдчилсан нэр	Байгууллага
А.Амарын талбайд	Орхон аймгийн Байгаль орчин, Аялал жуулчлалын газар
Б.Батжаргал	Орхон аймгийн Байгаль орчин, Аялал жуулчлалын газар
Г.Батжаргал	Орхон аймгийн Байгаль орчин, Аялал жуулчлалын газар
Д.Батжаргал	Орхон аймгийн Байгаль орчин, Аялал жуулчлалын газар
Е.Батжаргал	Орхон аймгийн Байгаль орчин, Аялал жуулчлалын газар





2. Хөрөнгө оруулалтын ажлыг чанаргүй хийж гүйцэтгэсэн байгууллага аж ахуй нэгжүүд болон бетон зурмагийн үйлдвэрт шалгалт хийж стандартын дагуу зуурмаг үйлдвэрлэж байгаа эсэх талаар хяналтыг мэргэжлийн багажаар хийж иргэдэд мэдээлэл хүргэх. Стандартын шаардлага хангаагүй үйлдвэрүүдийг зарлах (Барилгын зуурмаг, явган хүний замын хавтан, авто замын бордюр гэх мэт)

Хугацаа: Ойрын хугацаанд



Биелэлт: ХБТХОХ

Орхон аймагт 10 аж ахуй нэгж, байгууллагын 11 бетон зуурмагийн узель ажиллаж байна. БОАЖЯ-ны удирдамжийн дагуу 2023 оны 5 дугаар сарын 01-ний өдрөөс БОАЖГ-тай хамтарсан шалгалт хийж байна. Одоогоор шинээр байгуулагдсан 3, хуучин 4 узелийг шалгахад 3 аж ахуй нэгж, байгууллагын түүхий эд (хайрга, дайрга) зориулалтын бус талбайд хадгалж байгааг засах хугацаатай үүрэг өгсөн. Өнөөдрийн байдлаар барилгад нийлүүлсэн бетон зуурмагийн чанар муу байна гэсэн гомдол ирээгүй байна.

Хэрэгжилт: Хэрэгжиж байна.

ЧАНГАМДАА - ДЭМЖЭГД



3. Цагаан тоос дэд хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх чиглэлээр санал танилцуулах.

Хугацаа: Тухай бүрд





Биелэлт: ХБТХОХ

Цагаан тоосны дэгдэлт, сөрөг нөлөөллийг бууруулах дэд хөтөлбөр нь 2019-2022 онуудад хэрэгжиж дууссан тул тайланг аймгийн ИТХ-ын зөвлөлөөр хэлэлцүүлсэн. Цаашид дэд хөтөлбөрийг дахин боловсруулж батлуулах талаар аймгийн ИТХ-аас чиглэл өгсөн тул “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-тай хамтран боловсруулж байна. 2023 оны 5 дугаар сарын 12-ны өдөр цагаан тоосны дэгдэлт, сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр хийгдэж буй ажилтай аймгийн ИТХ-ын Байгаль орчин, хөдөө аж ахуйн хөгжлийн хороо, Эрх зүй нутгийн удирдлагын хөгжлийн хороо, аймгийн ИТХ-ын ажлын алба, аймгийн ЗДТГ болон бусад холбогдох албан байгууллагын албан тушаалтан, мэргэжилтнүүд газар дээр нь очиж танилцсан.

Хэрэгжилт: Хэрэгжиж байна.





4. Орон нутгийн үйлдвэр эрхлэгчдийг дэмжих, төрийн байгууллагууд зохион байгуулж байгаа арга хэмжээнүүдэд орон нутгийн бизнес эрхлэгчдийн бүтээгдэхүүнийг сонгоход анхаарч ажиллах.

Хугацаа: Тухай бүрд





Биелэлт: ХБТХОХ

Төрийн байгууллага болон төсөл хөтөлбөрөөс зохион байгуулж буй үйл ажиллагаа, үзэсгэлэн худалдаанд орон нутгийн үйлдвэрлэл эрхлэгчдийг тогтмол дэмжин оролцуулж байна. ЖДҮ хөгжүүлэх сан, Хоршоо дэмжих сан, ХХҮГ-ын хөнгөлөлттэй зээлд орон нутгийн үйлдвэрлэл эрхлэгчид хамрагдаж хөнгөлөлттэй зээл авсан.

Хүнсний дэлгүүрүүдэд орон нутагтаа үйлдвэрлэсэн 10 гаруй нэр төрлийн бараа, бүтээгдэхүүнийг борлуулах, тусад нь лангуу гаргах, нүүрний эгнээнд байрлуулж хэрэглэгчдэд хүргэх талаар мэдээлэл өгч гэрээнд тусган ажиллаж байна.

Төрийн байгууллагуудаас зохион байгуулж буй аливаа үйл ажиллагаанд орон нутагт үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүн, цэвэр усыг худалдан авч хэрэглэх талаар аймгийн Засаг даргаас гаргасан уриалгыг аймагт үйл ажиллагаа явуулж буй бүх төрийн байгууллагуудад албан тоотоор болон и-оффис системээр хүргэсэн.

Хэрэгжилт: Хэрэгжиж байна.



Батжаргал Сэмжид

2022.12.13 · 🌐

ЭРДЭНЭТЧҮҮДЭЭ УРИАЛАХ НЬ:

Аймгийн жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих, тэдний эдийн засгийн чадавхийг сайжруулах, цаашдын хөгжилд хувь нэмэр оруулах зорилгоор энэхүү уриалгыг гаргалаа.

Та бүхэн энэхүү уриалгыг дэмжин ажиллана гэдэгт итгэж байна.



ОРХОН АЙМАГТ
ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ ТӨРИЙН БОЛОН
ХУВИЙН ХЭВШЛИЙН ААНБ-УУДАД
УРИАЛАХ НЬ:

**"ОРОН НУТГИЙН ЖИЖИГ, ДУНД БИЗНЕСИЙН
ХӨГЖИЛ БА БИЗНЕС ТҮНШЛЭЛ"**



УУЛЗАЛТ ХЭЛЭЛЦҮҮЛГЭЭС
ҮНДЭСЛЭН АЙМГИЙН ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛ ЭРХЛЭГЧДЭЭ
ДЭМЖИХ ЗОРИЛГООР ЭНЭХҮҮ УРИАЛГЫГ ГАРГАЛАА.

ОРХОН АЙМАГТ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ



ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР,
ОРОН НУТГИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРУУД,
БАНК, САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА ТҮҮНИЙ САЛБАР НЭГЖҮҮД,
ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА, ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРҮҮД
ХУДАЛДАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРУУДАД УРИАЛАХ НЬ:

**ТА БҮХЭН АЛИВАА ҮЙЛ АЖИЛЛАГААНДАА
"ЭРДЭНЭТ"-Д ҮЙЛДВЭРЛЭСЭН**



БАРАА, БҮТЭЭГДЭХҮҮН, УС, УНДАА, КОФЕ, ЦАЙГ ХУДАЛДАН АВЧ
БИЗНЕС ЭРХЛЭГЧДЭЭ ДЭМЖИНЭ ҮҮ.
ТА БҮХНИЙ БОДИТ ДЭМЖЛЭГТ ОРОН НУТГИЙН
БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙН ЦААШДЫН ХӨГЖИЛД ИХЭЭХЭН
ХУВЬ НЭМЭР БОЛНО.



5. Цагаанчулуут багийн 49-53 дугаар гудамжны дахин төлөвлөлтийн ажлыг эрчимжүүлэх.

Хугацаа: Ойрын хугацаанд






Биелэлт: ХББЗА

Цагаанчулуут багийн 49-53 дугаар гудамжны дахин төлөвлөлтийн төсөл хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах бэлтгэл ажил хийгдэж байна. Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах захирамжийн төслийг боловсруулан удирдлагуудаас санал авах ажил хийгдэж байна. Энэхүү захирамж гарснаар нээлттэй сонгон шалгаруулалтыг зарлана.

Хэрэгжилт: Хэрэгжих шатандаа





6. А.Амарын талбайд төрийн байгууллагууд батлагдсан хуваарийн дагуу нээлттэй хаалганы өдрийг шинэлэг байдлаар зохион байгуулж иргэдэд ажлаа сурталчлах, төрийн үйлчилгээг газар дээр нь үзүүлэх чиглэлд онцгой анхаарах.

Хугацаа: Тухай бүрд





Биелэлт: ТЗУХ

Байгаль орчин аялал жуулчлалын салбарын байгууллагуудын “Нээлттэй хаалганы өдөр”-ийг 2023 оны 05 дугаар сарын 11-ний өдөр Амарын талбайд зохион байгуулсан. Тус өдөрлөгт аймгийн БОАЖГ, УЦУОШТ, ХХААГ, СХЗХ, СДОА, СГСГЗ, ЦНБГ, Баян-Өндөр сумын ЗДТГ, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, “Ачит-Ихт” ХХК, “Эрдмин” ХХК, “Зэс эрдэнийн хувь” ХХК, “Гал сэнтий” ХХК, 4-р сургуулийн Эко клубийн хүүхдүүд, мод үржүүлгийн үйл ажиллагаа явуулдаг 9 иргэн, 3 аж ахуй нэгж, байгууллага, 1 ойн нөхөрлөл зэрэг байгууллагууд оролцож байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр төрөөс болон орон нутгаас гаргаж буй бодлого, шийдвэр, арга хэмжээнүүдийг олон нийтэд танилцуулж, сурталчлан нийт 36 төрлийн 2600 орчим гарын авлага, ном товхимол, заавар зөвлөмж, тараах материалыг бэлтгэж 350 гаруй иргэд, 16 аж ахуй нэгж, байгууллагад заавар, зөвлөгөө өгч, гарын авлага, материалаар хангаж ажиллалаа. Иргэд, аж ахуй нэгж, байгууллагаас нийт 77 санал, хүсэлт хүлээн авч, холбогдох арга хэмжээг авч ажилласан.

Хэрэгжилт: Хэрэгжиж байна.





Биелэлт: ТЗУХ

2023 оны 05 дугаар сарын 12-ны өдөр “Нээлттэй хаалганы өдөр”-ийг Амарын талбайд Эрдэнэт хотын захирагчийн алба, “Эрдэнэт дулааны цахилгаан станц” ТӨХК, “Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК, “Орхон АЗЗА” ТӨХК, “Эрдэнэт ус, дулаан түгээх сүлжээ” ОНӨХК, Цэцэрлэгжүүлэлт, ногоон байгууламжийн газар, Хот тохижуулах газар, Мэдээлэл шуурхай удирдлагын төв, “Мэдээлэл холбооны сүлжээ” ТӨК, СӨХ зэрэг байгууллагууд зохион байгуулсан бөгөөд дээрх байгууллагууд нийт 217 иргэдээс санал, хүсэлт хүлээн авч газар дээр нь шийдвэрлэж, холбогдох газарт нь хүргүүлсэн.

Хэрэгжилт: Хэрэгжиж байна.





Биелэлт: ТЗУХ

2023 оны 5 дугаар сарын 13-ны өдөр Боловсрол, шинжлэх ухааны газрын “Нээлттэй хаалганы өдөр”-ийг Амарын талбайд зохион байгуулан нийт 3567 иргэд, суралцагчид боловсролын салбарын талаарх зөвлөгөө, мэдээлэл, шаардлагатай үйлчилгээг үзүүлсэн.

Хэрэгжилт: Хэрэгжиж байна.





7. “Соёлын сэргэлт – 2023” аяны хүрээнд зохион байгуулагдах соёл олон нийтийн арга хэмжээнүүдэд байгууллага бүр онцгой анхаарч оролцох.

Хугацаа: Тухай бүрд





Биелэлт: СУГ

"Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого төлөвлөлтийн хүрээнд бүх нийтийн соёлын боловсрол, соёлын хүртээмжийг нэмэгдүүлэх зорилготой "Соёлын сэргэлт-2023" аян 2023 оны 05 дугаар сарын 10-ны өдөр Орхон аймагт нээлтээ хийсэн.

Аймгийн Соёл урлагийн газар нь аяны хүрээнд Орхон аймагт 5 өдрийн турш зохион байгуулагдах хөтөлбөр, арга хэмжээний бэлтгэл ажлыг бүрэн хангаж, ЕБС-иуд, төрийн байгууллагуудыг оролцуулах, талаар мэдээллийг хүргэж, зохион байгуулалтыг хийж ажиллаж байна. Тус аяны нээлтийн арга хэмжээнд Соёлын дэд сайд, Орхон аймгийн Засаг дарга, Монголын уран зургийн галерейн захирал, "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын Хамтын ажиллагаа, нийгмийн харилцааны газрын дарга нар үг хэлж, үйл ажиллагаанд нийт 1000 орчим иргэд, ажилтан албан хаагчид оролцлоо. Аян үргэлжилж байна.

Хэрэгжилт: Хэрэгжиж байна.





АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА

2023 он

НАЙРАМДАА - ДУУЖДА